

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРААС “ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХАМТДАА” АЯНЫ
ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2018.06.09

Дархан

Зорилго: Дархан сумын хэмжээнд хамтарсан багийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, Монгол Улсын Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль түүнтэй нийцэж гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах, харилцан туршлага солилцох, хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулах, идэвхжүүлэхэд оршино.

ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЛААР:

д/д	Чиг үүрэг	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хийсэн ажил
1	Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулах сургалт	ЦБҮАЖ-ын код 316 “Хүүхдийн эрхийг хангах” сэдвээр сургалт зохион байгуулах, ЦБҮАЖ-ын код 314 “Эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй олдмол хүүхдийг бүртгэх” сэдвээр сургалт зохион байгуулах	Цагдаагийн алба хаагчдыг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэхэд сургаж, чадавхжуулах чиглэлээр давхардсан тоогоор 124 алба хаагчид ЦБҮАЖ-ын код 326, 316, 614, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, “Хүүхдийн эрхийг хангах”, “Эцэг эх нь, хэн болох нь тогтоогдоогүй олдмол хүүхдийг бүртгэх”, “Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авч шалгах”, “Аюулын зэргийн үнэлгээ хийх” зэрэг сэдвээр 5 удаагийн 6 цагийн сургалтыг зохион байгуулж, ХЭҮТөвөөс МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” нь багц сургалтанд 5 алба хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлээ.
		Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ХЭҮТ-ийн Дархан салбарын мэргэжилтэн, сэтгэл зүйч нартай хамтран сум, багийн түвшинд ажиллаж буй хамтарсан багийн гишүүдэд хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай онол, арга зүйн мэдлэг олгож, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах” сургалтыг Хонгор, Орхон, Шарын гол сумдад зохион байгуулж, Монгол улсын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүнийг дагалдан гарсан журмууд”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”, “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хохирогчийг таньж илрүүлэх”, “Хохирогчтой ажиллах үеийн сэтгэл зүй”, “Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, Нийгмийн халамжийн

			<p>тухай хуулийн танилцуулга, мэдээлэл” сэдвээр 24 цагийн сургалт зохион байгуулж, 3 сэдвийн хүрээнд бүлгээр ажиллаж хамтарсан багийн 56 гишүүн хамрагдсан.</p> <p>Дархан сумын 1-18 дугаар багийн хамтарсан багийн гишүүдийг хамруулан “Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарах асуудал” хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулж 122 гишүүн хамрагдаж, баг бүрт бичиг хэргийн хэрэгсэл, хамтарсан багийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр, гарын авлага зөвлөмж тараасан.</p>
2	<p>Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамтыг илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>Хүүхэд хамгааллын чиглэлээр хууль тогтоомж сурталчилсан, 1 видео шторк бэлтгэж мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр олон нийтэд түгээх</p>	<p>ЦЕГ, УСХ-ээс гаргасан 6 төрлийн видео шторкийг байгууллагын болон аймгийн ГХУСАЗСЗ-ийн веб сайтаар нэвтрүүлж, 1500 иргэн хандсан.</p>
		<p>Сургуулийн эргүүлийн үйл ажиллагааг сурталчилсан 1 видео шторк бэлтгэж мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр олон нийтэд түгээх</p>	<p>Монголын сурагчдын холбооноос гаргасан 3 төрлийн видео шторкийг ЕБ-ын 19 сургуулийн 4500 орчим багш, сурагч, эцэг эхэд сурталчлан танилцуулсан.</p>
		<p>“Амгалан-өрх” өдөрлөг зохион байгуулах /баг бүр дээр/</p>	<p>Дархан сумын 1-18 дугаар багийн нутаг дэвсгэрт “Амгалан өрх” өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж 125 айл өрхөөр орж гэр бүлийн нөхцөл байдалтай танилцаж, иргэдэд холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан. Дархан сумын ГХУСАЗСЗ-өөс Дархан сумын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Гэр бүл, хүүхдийн сайн сайхны төлөө хамтдаа” аяны хүрээнд ДС-ын 5-р баг, ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн гэмтэл, хүлээн авах, хүүхдийн тасаг, БСУГ, ГБХЗХГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах талаар уулзалт ярилцлага зохион байгуулж, Дархан сумын 5 дугаар багийн ИТХ, Засаг дарга, төрийн байгууллагуудтай хамтран “Амгалан өрх” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт төрийн 13 байгууллага, иргэд, оюутан, сурагчдын төлөөлөл 800-аад хүн хамрагдаж /ДС-ын ЗДТГ, ЭМГ, ГБХЗХГ, ЕБС, ХХҮХ, МСҮТ/ оролцож, гэр бүл, хүүхэд хамгаалал, гэмт хэрэг, зөрчил, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, багийн иргэдэд байгууллагын үйл ажиллагаагаа сурталчилж, 500 ширхэг гарын авлага, зөвлөмж тарааж, 32 хүнд хууль зүйн зөвөлгөө өгч</p>

		<p>Орон нутгийн телевизүүдээр Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамтыг илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээх</p>	<p>ажиллалаа.</p> <p>ЦЕГ-ын УСХ, Нийслэлийн болон бусад орон нутгийн цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэс, мэргэжилтнүүдээс гэр бүл, хүүхэд хамгаалал, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан 12 төрлийн шторк, “Сэргийлэгч хүү, Зөвлөгч охин-1,2,3,4 цуврал, “Хүүхэд нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй”, “Хүүхэд хамгаалал” зэрэг 17 зөвлөмж, мэдээлэл, контент, “Хайрлахын учир” драмын жүжгийг өөрийн болон байгууллагын веб сайт, пейж хуудас, олон хандагчтай группээр иргэдэд сурталчилж 760 хүн дэмжиж, 1300 хүн хандсан байна.</p> <p>Аймгийн ГБХЗХГ, БСУГ-тай хамтран хүүхдийг хүчирхийллээс хамгаалах нөлөөллийн арга хэмжээнд 9 хамтарсан баг, 15 ААН байгууллага, 11 сургууль, цэцэрлэг нийт 35 газрын 2160 иргэнийг хамруулж, “Хүүхэд нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй” мэдээлэл, 8 төрлийн шторк, зөвлөмжийг хандагч ихтэй групп, хамтран ажиллагч байгууллага, найз нөхдийн групп, веб сайтаар дамжуулан иргэдэд хүргэж, ажиллалаа.</p> <p>Аймгийн хэмжээнд охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийн, ялангуяа залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчийг буруутгах хандлагыг өөрчлөх зорилготой “Охид эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг 1 тэрбумаараа тэмцье” алхалт, флашмобийг аймгийн ГБХЗХГ-ын дэргэдэх, Залуучууд хөгжлийн төв, Насан туршийн боловсрол төвтэй хамтран зохион байгуулж Их, дээд, мэргэжлийн болон ерөнхий боловсролын 26 сургууль, 17 ААНБ уриалгад нэгдэж 470 иргэн оролцсон.</p> <p>Олон улсын “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” тэмдэглэлт өдрийг тохиолдуулан Мобиком, Скател, Юнител зэрэг үүрэн холбооны компаниудыг “Хүүхэд хамгаалал”-д хамтран ажиллахаар уриалж “Хүүхдийг зодож шийтгэх нь хүмүүжлийн арга биш” уриалга мессежийг Скателийн 5443, Юнителийн 24000 хэрэглэгчид хүргэж, нөлөөллийн ажлыг явуулсан.</p> <p>“Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас гаргасан хүүхдийн эрх, хамгааллыг сурталчилсан 6 төрлийн видео шторкийг хуулбарлаж цагдаагийн байгууллагын болон аймгийн ГХУСАЗСЗ-ийн вейб хуудсанд байршуулж иргэдэд сурталчилсан. Хүүхэд хамгааллын чиглэлээр 2 мэдээллийг</p>
--	--	--	--

		<p>оруулсан. 3 ААНБ-дад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулж, “Бодит байдал” нэвтрүүлэг арга хэмжээг нийт 47 алба хаагчдын хамруулан, гар дээрээс архи найруулж зарсан, зөвшөөрөлгүй тамхи зарсан зэрэг 3 зөрчлийг илрүүлж, хэсгийн байцаагч нараас ирүүлсэн мэдээллийн дагуу 2 өрхөөр зочилж эрх ашиг нь зөрчигдсөн 7 хүүхдийн хамгааллын асуудлыг шийдвэрлүүлэхээр хамтарсан багт холбон зуучилж, эцэг эхийг зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтанд хамруулж ажилласан.</p> <p>Орон нутгийн RGB, ЛХА, DBS телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж байгаа болон цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, камержуулалт, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын чиглэлээр нийт 7 удаа иргэдэд мэдээлэл хүргэж үйл ажиллагааг сурталчилж ажиллалаа.</p>
	<p>“Амрыг эрье”, “Бодит байдал”, “Сэргийлэгч” нэвтрүүлгээр сэдэв хөндсөн нэвтрүүлэг бэлтгэж мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх</p>	<p>“Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас гаргасан хүүхдийн эрх, хамгааллыг сурталчилсан 6 төрлийн видео шторкийг хуулбарлаж цагдаагийн байгууллагын болон аймгийн ГХУСАЗСЗ-ийн вейб хуудсанд байршуулж иргэдэд сурталчилсан. Хүүхэд хамгааллын чиглэлээр 2 мэдээллийг оруулсан. 3 ААНБ-дад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулж, “Бодит байдал” нэвтрүүлэг арга хэмжээг нийт 47 алба хаагчдын хамруулан, гар дээрээс архи найруулж зарсан, зөвшөөрөлгүй тамхи зарсан зэрэг 3 зөрчлийг илрүүлж, хэсгийн байцаагч нараас ирүүлсэн мэдээллийн дагуу 2 өрхөөр зочилж эрх ашиг нь зөрчигдсөн 7 хүүхдийн хамгааллын асуудлыг шийдвэрлүүлэхээр хамтарсан багт холбон зуучилж, эцэг эхийг зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтанд хамруулж ажилласан.</p>
	<p>Байгууллага, аж ахуйн нэгж болон их, дээд, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулиудад холбогдох хууль тогтоомжуудаар сургалт, сурталчилгаа, яриа таниулга хийх</p>	<p>“Хүүхэд хөгжил хамгаалал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын салбар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж эхэлсэн. 2018 оны эхний хагас жилийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Хуулиа мөрдье 21”, “Сэрэмжилье-нэгдье”, “Хуулийн хэрэгжилт”, “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээ, “Хүүхэд, гэр бүлийн сайн сайхны төлөө хамтдаа” аян, “Бид дэмжье-Та хичээ”, “Эргүүл, хяналт шалгалт-2018”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад олон нийтийн оролцоо”, “Сургалт-1, 2, 3”, “Цахим тоглоом-2018”, “Хүчирхийллийн эсрэг бид хамтдаа”, “Өсвөрийн сэргийлэгч –Эргүүл 2018”, “Төгсөлт-Эрдмийн</p>

			<p>баяр” хэсэгчилсэн арга хэмжээ зэрэг, “Хамтдаа ярилцах цаг”, “Ном унших цаг”, “Хүүхдэд ээлтэй гэр бүл”, “Хүүхэд хамгаалалд хамтдаа” өдөрлөг, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх орон нутгийн үйл ажиллагаа”, “Хуулиа мөрдье-21, Сэрэмжилье-нэгдье” хэлэлцүүлэг, “Архидалт –гэмт явдал” зөвлөгөөн, Охид эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг хамтдаа, “1 Тэрбумаараа тэмцье” алхалт, флашмоб, Дарханчууд хүчирхийллийг тэвчихгүй” зэрэг 26 удаагийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, хэлэлцүүлэг, зөвөлгөөнийг зохион байгуулж, аймгийн ГХУСАЗСЗ-өөс сургалт сурталчилгаа, гарын авлага, зөвлөмж, уриалга, шторк гаргах, нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулахад 2.844.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэж зарцуулсан.</p>
3	Эцэг эхийн оролцоонд түшиглэсэн ажил арга хэмжээ зохион байгуулах	“Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” дэлхийн өдрийг тохиолдуулан төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран өдөрлөг зохион байгуулах	<p>Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын алба хаагчдын хүүхдүүд мөн захиргааны хяналтанд байгаа болон гэмт хэрэг зөрчилд холбогдож, өртөж болзошгүй зорилтот бүлгийн хүүхдүүдэд урам хайрлаж, сэтгэлийн дэм өгөх, цагдаагийн байгууллага, төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн Иргэний нийгмийн нэгдсэн зөвлөлтэй хамтран “Хүүхдэд урам хайрлая” сэдэвт өдөрлөгийг цагдаагийн газрын хурлын зааланд зохион байгуулж, МУСТА Н.Мянганзам урлагийн тоглолтоороо бэлэг барьж, иргэний нийгмийн байгууллагуудаас 50 хүүхдэд гарын бэлэг гардуулж, хүүхэд эцэг, эхчүүдэд “Хүүхэд хамгаалал” гарын авлага 60 ширхэгийг тарааж, хууль тогтоомжийг сурталчилж ажиллалаа.</p> <p>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрийг тохиолдуулан “Автомашингүй өдөр”-ийг зохион байгуулж явууллаа. Автомашингүй өдөрийг Дархан 50 цогцолбор, Залуучууд театр, Хээтэй хороололын урд зам, шинэ хороололын урд замуудыг 2018 оны 06-р сарын 01-ний өдрийн 08 цагаас 20 цаг хүртэл хөдөлгөөнийг хааж хамгаалалт зохицуулалт хийж ажилласан.</p> <p>Цагдаагийн байгууллагын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Байгууллагын соёлыг дээшлүүлье” аян, Олон улсын гэр бүлийн өдрийг угтаж алба хаагчид тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулан “Гэр бүлийн аз жаргал-Амжилтын үндэс” зөвөлгөөнийг зохион байгуулж 160 алба хаагч гэр бүлийн хамт оролцож, “Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, ажлын онцлог, үнэлэмж”, “Хүүхдийн хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалт, мэдээллийг хийж, санал хүсэлтийг сонсож, гэр бүлийн харилцаанд</p>

			<p>амьдралын зөв хэвшил, эерэг нөлөөллийг төлөвшүүлэх ажлыг зохион байгууллаа.</p> <p>Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” Олон улсын өдрийг угтаж “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлье” уриан дор нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 15 ААНБ, 360 иргэдэд хууль тогтоомжийг сурталчилж, гарын авлага, зөвлөмж 300 ширхэгийг тарааж,Мобиком, Скател, Юнител зэрэг үүрэн холбооны компаниудыг “Хүүхэд хамгаалал”-д хамтран ажиллахаар уриалж “Хүүхдийг зодож шийтгэх нь хүмүүжлийн арга биш” уриалга мессежийг Скателийн 5443, Юнителийн 24000 хэрэглэгчид хүргэж нөлөөллийн ажлыг явууллаа.</p>
--	--	--	--

 pdfelement

		<p>“Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх” чиглэлээр олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>Хүүхдийг зам тээврийн хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийт, хүүхэд багачуудад зам тээврийн осол хэргийн хор уршгийг таниулах, замын хөдөлгөөнд оролцох дадлыг зөв хэвшүүлэх, эцэг,эх асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын 11 сургууль, СӨБ-ийн 9 цэцэрлэгийн нийт 700 сурагч, хүүхэд багачууд, 5 ААНБ-ын 480 ажилтанд “Замын хөдөлгөөний дүрэм, аюулгүйн бүс”, “Хүүхдийн хамгаалалтын суудал”, “Зөрчлийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн холбогдох заалтаар сургалт зохион байгууллаа.</p> <p>СӨБ-ын хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2018” тэмцээнийг зохион байгуулж 22 цэцэрлэгийн 240 хүүхэд баг нар амжилттай оролцож тэмцээнд зарцуулагдах 2 сая 600,000 төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ-өөс шийдвэрлэсэн.</p> <p>“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа шийдье” төвийн бүсийн зөвөлгөөнийг 2018 оны 5 дугаар сарын 11-ны өдөр Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн Цагдаагийн газрын удирдлагууд, Замын цагдаагийн тасгийн алба хаагчдыг хамруулан зохион байгуулж, “Зөвлөмж “ гаргаж иргэд олон нийтэд хүргэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэж ажиллалаа.</p> <p>Аймгийн ГХУСАЗСЗ-өөс гаргасан “Цахим гэмт хэрэг”, бага насны хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор HD 1080 форматаар бэлдсэн 2 төрлийн богино хэмжээний анимешнийг ЗЦА-ны орон нутгийн замын цагдаа фейсбүүк хаягт байрлуулан, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.</p> <p>Аймгийн БСУГ, ГБХЗХГ-ын хүүхдийн элчтай хамтран “Хүүхдийн ертөнц” гар зураг, ЭССЭ бичлэгийн уралдааныг “Миний гэр бүл-Миний бахархал”, “Цахим гадуухал цаашаа”, “Цахим орчны зохистой хэрэглээ-зөв дадал” зэрэг 7 сэдвийн хүрээнд зохион байгууллаа. ЕБ-ын Оюуны ирээдүй, Од цогцолбор, 16, 9, Монгол-Оюу сургуулийн сурагчид идэвхитэй оролцож 140 хүүхдийн бүтээлийг шалгарууллаа.</p>
		<p>“Өсвөрийн сэргийлэгч” бүлгэм, “Оюутан цагдаа”, “Сургуулийн эргүүл”-ийн үйл</p>	<p>Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм” ажиллах журмыг сурталчлан таниулах, ерөнхий боловсролын сургуулиудын</p>

		ажиллагааг эрчимжүүлэх	<p>“Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийг шинэчлэн байгуулах, гишүүдийг чадавхижуулах, сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх ажилд бүлгэмийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн БСУГ-тай хамтран “Өсвөрийн сэргийлэгч-эргүүл 2018” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж,</p> <p>12 сургуулийн 32 багш, сурагч оролцож, тангараг өргөж, үнэмлэх гардууллаа. ЕБ-ын 22 сургууль дээр “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм” ажиллах журмын дагуу байгуулагдаж, 220 гишүүнтэйгээр ажиллаж байна.</p> <p>Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн гишүүд, эцэг эх, багш нарын хамтарсан 270 хүн эргүүлд ажиллаж, 161 хүнд зөвлөгөө өгч, 52 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, “Сургуулийн цагдаа” эргүүлд 27 сургуулийн 1800 эцэг, эх эргүүлийн үүрэг гүйцэтгэж, Монголын сурагчдын холбооны Дархан салбартай хамтран 3 удаагийн зураг авалт хийж, БСУГ-ын удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулж, сургуулийн удирдлага, багш, ажилтны удирдлага, хяналтыг сажйруулахад анхаарч ажиллалаа.</p> <p>“Оюутан цагдаа” эргүүлд 10 сургуулийн 750 оюутан эргүүлийн үүрэг гүйцэтгэж, цагдаагийн байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах хамтран ажиллаж 3 зөрчлийг илрүүлж, хариуцлага тооцсон.</p>
4	Хариуцсан багт объект, субъектын судалгааг шинэчлэн баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа	<p>Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд эрсдэлд өртөж болзошгүй 16 хүүхдийг бүртгэлд авч, хяналт тавьж ажиллалаа.</p> <p>“Хүүхдэд ээлтэй гэр бүл” өдөрлөгийг ерөнхий боловсролын 3 сургууль дээр сурагч, багш, эцэг эхийг хамруулан зохион байгуулж 160 гаруй эцэг эх, 320 сурагч, багш хамрагдаж, хүүхэд хамгааллын чиглэлээр “Зөвлөмж” 200 ширхэгийг түгээж хамтран ажилласан.</p> <p>Эрсдэлт нөхцөлд амьдардаг 20 хүүхдийг “Сайхан сэтгэл-Сайн үйлс” аяны хүрээнд эд материалын тусламж, үйлчилгээнд хамруулсан.</p> <p>Хүүхэд хамгааллын хүрээнд хүүхдийн эрхийг гэр бүл, сургуулийн орчинд эрхэмлэн дээдлэх, хүүхдийн дуу хоолойг сонсох, үе тэнгийн дарамт шахалтыг илрүүлж, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор аймгийн ГБХЗХГ, ХХҮХ, ЕБ-ын Энэрэл цогцолбор сургуулийн удирдлагатай хамтран “Хүүхэд</p>

		<p>бидний дуу хоолой-Бодлогын мэтгэлцээн"-ийг зохион байгуулж 5-12 дугаар ангийн 7 багийн 96 багш сурагчдын төлөөлөл идэвхтэй оролцож, "Хүүхдийн эрх, хамгаалал хүмүүжил төлөвшил, цахим орчинд соёлой, хүндэтгэлтэй хандъя"сэдвийн хүрээнд мэдээллэл хийж, гарын авлага 50 ширхэгийг тарааж, дунд, ахлах бүлгийн сурагчдын дунд "Мини-Шүүх" хурлын үйл ажиллагааг зохион байгуулж 46 сурагч хамрагдаж, хүүхдүүдэд гарын авлага, материал 50 ширхэгийг тарааж өгсөн</p>
	Хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл	<p>Аяны хугацаанд эцэг эхийн хараа хяналтгүй төөрсөн, тэнэсэн 11 хүүхдийг эрэн сурвалжилж, эцэг эх асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, хамтарсан багийн үйлчилгээнд 3 хүүхдийг холбон зуучилсан.</p>
	Сургууль завсардсан хүүхдийн бүртгэл	<p>"Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг байж болзошгүй" 12 өрхийг судалгаандаа авч сургуулиас завсардсан Дархан сумын 6 дугаар баг 73-09 тоотод оршин суух Ерөнхий боловсролын 16 дугаар 9г ангийн сурагч Б.Билгүүн, 6в ангийн сурагч Б.Дөлгөөн, Дархан сумын 8 дугаар баг 17 дугаар хороолол 10-15 тоотод оршин суух Ерөнхий боловсролын 6в ангийн сурагч Эмүүжин нар нь 1-3 сарын хугацаанд хичээл завсардсан байх тул, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй хүүхдийн судалгаанд авч хамтарсан багаар хуралдаж ЕБ-ын 16-р сургуулын нийгмийн ажилтан Алтанцэцэгтэй хамтран ар гэрийнхэнээс нь баталгаа гаргуулан авч 9 дүгээр анги төгссөн Б.Билгүүнийг Дархан Өргөө сургуульд суралцуулахаар бүртгүүлэн ажиллаж байна. Дархан сумын 2 дугаар баг Октябрын 6-2 тоот Наранцэцэгийн Мөнгөншагай, Дархан сумын Хушаатын 3-04 тоотод оршин Номинбат, Номинбаяр нарын сургуульд завсардсан 3 хүүхдийн ар гэртэй хамтран хамтарсан багаар хуралдаж "Насан туршийн боловсролын төв"-д сургуульд оруулсан.</p> <p>Сургууль завсардсан 2 хүүхдийг илрүүлж, эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгч, хүүхдийн эрхийн</p>

		зөрчил гаргахгүй байхыг зөвлөж, 1, 4-р сургуулийн нийгмийн ажилтантай хамтран ажилласан.
	Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийн судалгаа	Иргэд, ААНБ-д 24 удаагийн сургалт сурталчилгаа зохион байгуулж 2100 хүн хамрагдаж, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх санал хүсэлтээр 5 гэр бүлийг илрүүлж, хяналтанд авч холбон зуучилсан.
	Согтууруулах ундаа болон, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэдэг иргэдийн судалгаа	“Архигүй монгол хүн” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГазар, ХЭЗүйн хэлтэс, ЭМГазар, Анхан шатны иргэний хэргийн шүүх, Прокурорын байгууллагуудтай хамтран гэр бүл орчиндоо байнга архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг 16 хүнийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан архинд донтох өвчтэй эсэхийг тогтоолгон, шүүх хурлаар оруулж албадан эмчилгээнд хамруулах шийдвэр гаргуулан 2018.04.27-ны өдөр Төв
	Хамтарсан багийн үйлчилгээнд хамруулсан иргэдийн бүртгэл	аймгийн Баян сум дахь согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгүүлэх газарт хүргэж эмчилгээд хамрууллаа. Цагдаагийн албаны тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4.4-д заасныг үндэслэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн газарт цагдаагийн алба хаагчаас үзүүлэх, тусламж, бусад шаардлагатай мэдээллийг хохирогчид өгөх “Тусламжийн хуудас”-ыг 700 ширхэгийг хэвлүүлж жижүүрийн алба, хэсгийн байцаагч, эргүүлийн алба хаагч, хэсгийн төлөөлөгч нарт хуваарилан өгч, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл өгсөн болон бусад 295

			иргэдэд тарааж, эрх үүргийг нь танилцуулж, аюулын зэргийн үнэлгээг 53 хүнд хийж, хамтарсан багийг 27 удаа хуралдуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллалаа.
5	Хариу үйлчилгээ, холбон зуучлах	Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулах	Хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүмүүсийг илрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор хууль тогтоомжоор үүрэг хүлээлгэсэн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Хүчирхийллийн эсрэг бид хамтдаа” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж сум, багийн хамтарсан багийн 86 гишүүдэд 3 удаагийн сургалт зохион байгуулж, “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн ойлголт, хандлагыг тодорхойлох” судалгааг цахимаар болон биечлэн 220 иргэнээс авч, 60 айл өрх, 19 ААНБ-аар зочилж, гарын авлага, зөвлөмж 100 ширхэгийг тараасан.
		Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээний төлөвлөлт хийх, хэрэгжилтийг хангах	“Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хүрээнд хамтарсан багийн үйл ажиллагааг чадавхижуулах, эрчимжүүлэх 3 удаагийн сургалтанд 4 цагийн сургалт зохион байгуулж, бүлгээр ажиллуулж, гарын авлага 50 ширхэгийг тараан өгсөн.
		Хүчирхийлэлд өртсөн, хараа хяналтгүй хүүхдийн талаарх 102, 107, 108 дугаарын утсанд ирсэн дуудлага, мэдээллийн судалгааг гаргаж, харьяа нутаг дэвсгэрийн “Хамтарсан баг”-ийн хяналтанд өгөх ажлыг зохион байгуулах	Хүүхдийн тусламжийн 108 дугаарт 76 дуудлага мэдээлэл хандсаны 68 орчим хувь нь гэр бүлийн хүрээнд хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн мэдээлэл зонхилж байгаад дүгнэлт хийж, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр анхаарч ажиллалаа. Аймгийн ХЭХЗ хороо эхний улиралд 1 удаа хуралдаж 15 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, хамтарсан багт 2 хүүхдийн хамгааллын асуудлыг шийдвэрлүүлэхээр холбон зуучилж, хууль зүйн сэтгэл зүйн зөвлөгөөнд 13 хүүхдийг хамруулж, нийгмийн халамжийн үйлчилгээнд 5 хүүхдийг хамрууллаа.
		Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн ойлголт, хандлагын түвшинг тодорхойлох тандалт судалгааг авах	“Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн ойлголт, хандлагыг тодорхойлох” судалгааг цахимаар болон биечлэн 260 иргэнээс авч, 60 айл өрх, 19 ААНБ-аар зочилж, гарын авлага, зөвлөмж 100 ширхэгийг тараасан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, илрүүлэх, хүүхдийг гэмт хэрэг зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласнаар 2018 оны эхний 5

			сарын байдлаар Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 14 бүртгэгдэж урьд оны мөн үеэс 15 хэргээр буюу 51.7 хувиар буурч, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд 13 бүртгэгдэж 13.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
--	--	--	--

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

ГБХХЭГХУСАХ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Ж.БАЯРЧИМЭГ

ХЯНАСАН:

ДЭД БӨГӨӨД, ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

С.ХУРЦ

 pdfelement